

Дүүргүүдийн ИТХ-ын ажлын алба, ЗДТГ-ын хэлтэс, албадын ажилтнуудад сургалт зохион байгууллаа

Статистикийн албаны 91 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан 2015 оны 11 сарын 05, 06-ны өдрүүдэд ҮСХ болон дүүргүүдийн Статистикийн хэлтэс хамтран дүүргүүдийн ИТХ-ын ажлын алба, ЗДТГ-ын хэлтэс, албадын ажилтнуудад батлагдсан хөтөлбөрийн дагуу сургалт зохион байгууллаа.

БАЯНГОЛ ДҮҮРЭГ



2015.11.05. ҮСХ болон Баянгол дүүргийн Статистикийн хэлтэс хамтран Баянгол дүүргийн ИТХ-ын ажлын алба, ЗДТГ-ын хэлтэс, албадын нийт 61 ажилтанд батлагдсан хөтөлбөрийн дагуу сургалт зохион байгууллаа. Тус сургалтад ҮСХ-ны МССТ-ийн дарга А.Дэмбэрэл, СХ-ийн мэргэжилтэн Х.Бадмаанямбуу нар “Статистикийн мэдээллийг хаанаас авах вэ”, “Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн хэрэглээ”, “Хүн ам орон сууцны завсрын тооллого-2015” сэдэвт илтгэл тавьж, сургалтанд оролцогчдын асуусан асуултанд хариулт өглөө.

ХАН-УУЛ ДҮҮРЭГ



2015.11.05. Сургалтыг Хан-Уул дүүргийн Статистикийн хэлтсийн дарга О.Гэрэл нээж, ҮСХ-ны МССТ-ийн шинжээч Г.Батбуян “Статистикийн мэдээллийг хаанаас авах вэ”, тус

хэлтсийн ахлах мэргэжилтэн Ц.Энх-Оюун “Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн хэрэглээ - Хүн ам орон сууцны завсрын тооллого-2015” сэдвээр мэдээлэл хийлээ. Сургалтад дүүргийн ИТХ-ын ажлын алба, ЗДТГ-ын хэлтэс, албадын 30 гаруй ажилтнууд оролцож, сонирхсон асуултандаа хариулт авлаа. Мөн оролцсон нийт ажилтнуудад “Хан-Уул дүүрэг-2014” нугалбар, CD, тооллогын сурталчилгааны брошур тараав.

БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ



2015.11.06. Баянзүрх дүүргийн ИТХ-ын ажлын алба, ЗДТГ-ын хэлтэс, албадын ажилтнуудад МССТ-ийн мэргэжилтэн Б.Мягмархатан, “Хүн ам, орон сууцны завсрын тооллого-2015” сэдвээр БЗД-ийн Статистикийн хэлтсийн дарга Н.Энхтуяа “Хүн ам, орон сууцны завсрын тооллого-2015” сэдвээр сургалт зохион байгуулж, оролцогчдын асуултад хариуллаа.

СҮХБААТАР ДҮҮРЭГ



2015.11.06. Сүхбаатар дүүргийн Тамгын газрын ажилтнуудад “Статистикийн мэдээллийг хэрхэн авах вэ” сэдвээр МССТ-ийн мэргэжилтэн А.Мөнхцэцэг, “Хүн ам, орон сууцны завсрын тооллого-2015” сэдвээр СБД-ийн Статистикийн хэлтсийн дарга Д.Нарантуяа нар сургалт зохион байгууллаа. Сургалтад тус дүүргийн Тамгын газрын 47 албан хаагчид

оролцож, статистикийн мэдээллийг хаанаас хэрхэн авч ашиглах талаар болон Хүн ам, өрхийн бүртгэлээ хэрхэн шалгаж баталгаажуулах талаар мэдээлэл авлаа.

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ



2015.11.06. Тус дүүргийн ИТХ-ын ажлын алба, ЗДТГ-ын хэлтэс, албадын ажилтнуудад ҮСХ-ны МССТ-ийн шинжээч Э.Оюунцэцэг "Статистикийн мэдээллийг хаанаас хэрхэн авах вэ", СХД-ийн Статистикийн хэлтсийн дарга Б.Алтангэрэл "Хүн ам, орон сууцны завсрын тооллого-2015" сэдвээр сургалт зохион байгуулж, оролцогчдын асуултад хариуллаа.

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ



2015.11.06. Тус сургалтыг Тамгын газрын дарга Ж. Эрдэнэбат нээж, ҮСХ-ны МССТ-ийн ахлах шинжээч Л.Элбэгсайхан "Статистикийн мэдээллийг хаанаас хэрхэн авах вэ", Чингэлтэй дүүргийн Статистикийн хэлтсийн дарга Д.Мөнхзул "Хүн ам, орон сууцны завсрын тооллого-2015" сэдвээр дүүргийн Засаг даргын тамгын газар, Иргэдийн хурлын төлөөлөгчдийн ажлын албаны дарга, мэргэжилтэн нийт 45 ажилтанд сургалт зохион байгуулж, оролцогчдын асуултад хариуллаа.

МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ТӨВ